



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022. 04. 22 № 20

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮН, ШАДАР
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА

Г Асуулга тавих тухай Т

Оросын Холбооны Улсаас Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улстай холбох байгалийн хийн хоолой барьж байгуулах боломжийг судлах харилцан ойлголцлын санамж бичигт 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын «Газпром» НХН гарын үсэг зурж, 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдөр ажлын хэсэг байгуулснаа мэдэгдсэн байдаг.

Монгол Улсын тухайд байгалийн хий дамжуулах хоолойг өөрийн нутгаар дамжуулах нь эдийн засаг болон гадаад харилцааны хувьд ашигтай эсэх, давуу болон сул тал, эрсдэлийг сайтар тооцоолж, өнөө үе болоод өнө хойчдоо үр өгөөжтэй байх хариуцлагатай шийдвэр гаргах цаг үе тулгараад байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн, Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:


1. ОХУ болон БНХАУ-ын хооронд байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулах талаар тодорхой гэрээ, хэлэлцээр эцэслэн хийгдсэн эсэх талаар;
2. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд сонгогдсон эсэх болон тэдгээрийн холбогдох мэдээллийн талаар;
3. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойн ТЭЗҮ хийгдсэн эсэх талаар;
4. Хийн хоолойгоор жилд хичнээн хэмжээний хий дамжуулах, түүний төлбөрийг хэрхэн тооцох талаар;
5. Байгалийн хийн хоолой нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийт хэдэн хавтгай дөрвөлжин километр талбайг хамрах талаар;
6. Төсөл хэрэгжиж эхэлсэн тохиолдолд хоолойн хамгаалалтыг төсөлд оролцогч талуудын аль нь хэрхэн хариуцах талаар;
7. Монгол Улс тус хийн хоолойн завсрын хэрэглэгч болсон тохиолдолд жилд хэдий хэмжээний хий худалдаж авахаар төлөвлөж буй талаар;
8. Байгалийн хийн хоолойг дагаж баригдах дотоодын хэрэгцээнд нийлүүлэх хоолой, дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлын тооцоо, тэдгээрийг

2022000035

хаанаас, хэрхэн санхүүжүүлэх, цаашид аль талын өмчлөл, эзэмшилд үлдэх, Монгол Улсад өгөх өгөөж зэргийн талаар тус тус дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэн ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын Хяналт, шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг Танаас хүсье. Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Н.ГАНИБАЛ

2022000035